НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 14 өдөр Дугаар А/24 Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах
цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт
гимнастикийн тэмцээнийг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Улаанбаатар хотын аварга шалгаруулах цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг 2023 оны 05 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд "Спортын төв ордон"-д зохион байгуулсугай.

2.Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 15,460,000 (арван таван сая дөрвөн зуун жаран мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, уралдаан тэмцээний зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2023 оны .04. дүгээр сарын ..14. -ны
өдрийн ..А/94.. дүгээр тушаалын хавсралт

ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН УРАН ХӨДӨЛГӨӨНТ
ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төг)	Нийт дүн (төгрөг)
1.	Тамирчдын шагнал	1-р байр	33 хүн	30,000	990,000
		2-р байр	33 хүн	20,000	660,000
		3-р байр	66 хүн	10,000	660,000
2.	Шүүгчдийн зардал		10 хүн х 2 өдөр	50,000	1,000,000
3.	Баг, номинаци шагнал		6	250,000	1,500,000
4.	Заалны түрээс		-	-	1,200,000
5.	Цомны зардал		12	60,000	720,000
6.	Өргөмжлөлийн зардал		12	60,000	720,000
7.	Хулдаасан хэвлэл		80 мкв	12,500	1,000,000
8.	Карказ, чимэглэл, гэрэлтүүлэг, тайз		-	-	2,000,000
9.	Бичиг, хэргийн зардал		-	-	470,000
10.	Хөтлөгч		-	-	1,000,000
11.	Бичлэг хийх, зураг авах		-	-	300,000
12.	Медаль		132 ш	20,000	2,640,000
13.	Зохион байгуулагч, шүүгчдэд зориулсан цай, кофе, ус, ундааны зардал		-	-	600,000
				Дүн	15,460,000